

ХЯТАД-МОНГОЛЫН ХИЛИЙН БҮСИЙН ХУДАЛДААНД ЮАНИЙГ ХЭРЭГЛЭХ НЬ

Ма.Бүрэнжаргал*

Хятад, Монголын 3211 км хилийн шугам дээр Хятад улс 11 хилийн боомт нээжээ. Хоёр орон 1988 оноос хилийн худалдааг эхлүүлснээс хойш хоёр талын худалдааны хэмжээ тасралтгүй нэмэгдэж, худалдаа хийгээд хил дамнасан тооцоонд юан улам өргөн хэрэглэгдэх болжээ. Жишээ нь 2011 оны эцэст Эрээн хотын худалдааны банкаар дамжин юанаар хийсэн тооцоо 382.8 тэрбум байсан нь юаниар хийсэн бүх тооцооны 80.7 хувийг эзэлжээ.¹

Юанаар тооцоолох нь хилийн худалдаа арилжаа явагдахад дөхөм үзүүлсэн ба энэ нь Хятад улсын бусад мужууд хөрш улсуудтай юанаар тооцоо хийхэд тун сайн үлгэр жишээ болжээ. 2011 оны сүүлээр Өвөр Монголын Өөртөө Засах орны 7 арилжааны банк Монгол улсын 14 арилжааны банктай юанаар тооцоолох данс 31-ийг байгуулжээ.

Хятадаас Монголд оруулсан хөрөнгийн нийт хэмжээ 2009 онд 1 060 тэрбум, 2010 онд 2 390 тэрбум, 2011 онд 16 840 тэрбум юан байжээ. Юаны ханшаар илэрхийлсэн хөрөнгө оруулалт 2009, 2010 онд тус тус 100 тэрбум, 260 тэрбум байсан бол 2011 онд 1 860 тэрбум болж өссөн байна²

2005 оны дунд үеэс Монгол руу хил дамнасан хөрөнгө оруулалт нь Монголын уул уурхайн эрэл хайгуул хийгээд зам харилцааны салбар луу чиглэсэн байна. Сүүлийн жилүүдэд Хятадын тал нэр хүндтэй, эдийн засгийн өндөр чадвартай компаниудыг Монголын хөрөнгө оруулалтын зах зээлд орохыг хүчтэй дэмжсэнээр хилийн боомт дахь хөрөнгө оруулалтын ерөнхий хэмжээ өссөн байна.

2009-2011 онд Эрээн хотын боомтоор дамжин орж гарсан хүний нийт тоо 54 203 түмэн хүн байж, үүнийг дагаад бэлэн мөнгөний хэмжээ 107 553 сая юан байв. Тэр дундаа Хятадаас Монгол руу хувь хүмүүс биедээ бэлнээр авч гарсан юаны хэмжээ 53 941 сая юан байсан бол Хятад руу орж ирсэн юаны хэмжээ 53 612 сая байв.³

* Өвөр Монголын Их Сургуулийн Монгол судлалын дээд сургуулийн багш, доктор (Ph.D)

1. Гуо Бин /郭斌/, Ван Ли Ли зэрэг /王丽丽 等/: “Юан болон хөрш орны үндэсний валютын хоорон дахь валют ханшны тухай”(L), “Баруун орны мөнгө санхүү” 2012, №3, 73-76-р тал: “加快人民币与周边小币种直接汇率挂牌探析”(L), 《西部金融》, 2012 (3), 73-76.

2. Жан И Жүн /张义军, Ген Фэн Жү /耿凤柱/: “Хятад Монголын хил залгасан оронд юаны эргэлдэж байгаа байдал”(L), “Өвөр монголын мөнгөн гүйлгээ судлал” 2012 №9., 48-49-р тал: “中蒙边境地区人民币区域化情况调查”(L), 《内蒙古金融研究》, 2012 (9), 48-49.

3. Гуо Бин /郭斌/, Ван Ли Ли зэрэг /王丽丽 等/: “Юан болон хөрш орны үндэсний валютын хоорон дахь валют ханшны тухай”(L), “Баруун орны мөнгө санхүү” 2012, №3, 73-76-р тал: “加快人民币与周边小币种直接汇率挂牌探析”(L), 《西部金融》, 2012 (3), 73-76.

Хоёр орны эдийн засгийн харилцааны хөгжлийг дагалдан Замын-Үүд болон Улаанбаатар хотод юаны эргэлт нилээд их байна.⁴

Хятад-Монголын худалдаанд аялал жуулчлалын худалдааны эргэлт нилээд их хувийг эзэлдэг. Аялал жуулчлалын худалдаанд гол төлөв бэлэн мөнгөөр (юанаар) тооцоо хийдэг байна. Энэ нь хилийн боомт орчимд юаны бэлнээр орж гарах хэмжээг нэмэгдүүлжээ. Мөн Монгол улс руу бэлэн мөнгө хэлбэрээр орсон юань нь буцаж гарч ирэх зам шугам хомс байдгаараа их хэмжээний юань Монгол улсад төвлөрсөн байна.

Барагцаалбал, Монгол руу орсон бэлэн юаны хэмжээ 2009 онд 2 342 сая юан, 2010 онд 5 218 сая юан, 2011 онд 16 290 сая юан байжээ. Тэгвэл, Монголоос Хятад руу буцаж орсон бэлэн юаны хэмжээ 2009 онд 946 сая, 2010 онд 2 306 сая, 2011 онд 12 669 сая юан байсан байна. Үүнээс үзэхэд, юаны хил дамнасан эргэлт нь ерөнхийдөө гадагш чиглэсэн урсгалтай, гадагш гарсан цэвэр хэмжээ нь 2009 онд 1 396 сая, 2010 онд 2 906 сая, 2011 онд 3 621 сая юан тус тус байжээ.⁵

2009, 2010, 2011 онд Монгол улсын хил дотор хуримтлагдаж байгаа юаны хэмжээ нь тус онуудад 11 800 сая, 13 300 сая, 19 700 сая байж тухайн жилүүдэд тус бүр 203.8 хувь, 12.14 хувь 48.33 хувиар нэмэгджээ.⁶

Тулгамдсан асуудлууд

1. Бэлэн мөнгөөр тооцоо хийх нь хилийн худалдааны тооцооны гол хэлбэр болж байна. Хятад улс нь 10 гаруй жилийн турш Монголын хамгийн том худалдааны түнш хийгээд хөрөнгө оруулагчийн байр суурьтай байсаар иржээ. Гэтэл хоёр талын мөнгөн гүйлгээ хийх тогтолцоо нь хил давж төлбөр тооцоо хийх чадвартай байсангүй. Банк хоорондын тооцооны данс байгуулаагүй байснаас хилийн боомтын худалдаанд мөнгө гуйвуулах, валют солих зэрэг ажиллагаа шууд явагдаж чадахгүй байжээ. Мөнгөн гүйлгээний үйлчилгээ дутмаг байгаа нь хилийн худалдаа хөгжихөд саад болж байна. Хил дамнасан юаны тооцоог бий болгох нь зайлшгүй шаардлагатай юм. Гэвч одоо болтол энэ талын уялдаа зохицуулалт дутагдаж байгаагаас шалтгаалан хилийн чанад дахь юаны эргэлтэд ихээхэн саад учирч байна.

2. Монгол талын банк хоорондын валютын ханшны тогтолцоо мөн зохистой бус байна. Монгол төгрөг болон юань нь чөлөөтэй хөрвөдөг валют биш юм.

4. Дэн Жүн /邓忠/, Жао Мин /赵明/, Бао Жи Жүн /包志忠/: “Хилээр бэлнээр гарч байгаа юаныг хязгаарлах тогтоол Эрээний хилийн боомтын худалдаанд үзүүлсэн нөлөө” (L), “Өвөр монголын мөнгөн гүйлгээ судлал” 2012 №5., 36-37-р тал.: “携带人民币出入境限额规定对二连口岸贸易发展的影响”(L)·《内蒙古金融研究》·2012 (5), 36-37.

5. Гуо Бин /郭斌/, Ван Ли Ли зэрэг /王丽丽 等/: “Юань болон хөрш орны үндэсний валютын хооронд дахь валют ханшны тухай”(L), “Баруун орны мөнгө санхүү” 2012, №3, 73-76-р тал: “加快人民币与周边小币种直接汇率挂牌探析”(L),《西部金融》, 2012 (3), 73-76.

6. Жан И Жүн /张义军, Ген Фэн Жү /耿凤柱/: “Хятад Монголын хил залгасан оронд юаны эргэлдэж байгаа байдал”(L), “Өвөр монголын мөнгөн гүйлгээ судлал” 2012 №9., 48-49-р тал: “中蒙边境地区人民币区域化情况调查”(L),《内蒙古金融研究》, 2012 (9), 48-49.

Хоёр талын банкны хооронд үндэсний валютын тооцоо болон солилцоо явагдахад заавал Америк доллараар шилжүүлж бодож байна. Монголын арилжааны банкууд Төв банкныхаа зарласан Монгол төгрөг болон юаны дундаж ханшийг үндэслэн өөр өөрсдийнхөөрөө ханшийг тогтоодог байна. Зах дэлгүүрийн эрэлт, нийлүүлтийн байдлыг харгалзаж цаг тухайд нь валютын ханшийг өөрчилдөг учраас валютын ханшны хэлбэлзлийн давтамжийг ихээр үүсгэдэг. Хятадын төв банк нь ч гэсэн юань хийгээд Монгол төгрөгийн харьцсан валютын ханшийг тодорхой зарлаагүй байгаа тул энэ нь мөн хүмүүсийн банкаар дамжиж тооцоолох ба гадаад мөнгө солих байдалд сөргөөр нөлөөлж байна.⁷

Үүнээс гадна Хятадын банк нь төгрөгийн хувьд дотооддоо их хэмжээгээр хадгалахыг зөвшөөрдөггүй тул арилжааны банкууд нь төгрөгийн валют ханшны хэлбэлзлээс үүсэж болох хохиролын эрсдэлийг өөрөө хүлээдэг учраас тэдний төгрөгийг хүлээн авах байдал нь муу байдаг ба хилийн боомт дахь мөнгөн гүйлгээний байгууламжуудын Монгол төгрөгийг хүлээн авах идэвхжлийг сулруулдаг.

3. Монголын засгийн газрын эдийн засагт холбогдох төрийн бодлого нь тогтвортой чанараар муу, Монгол улсын улс төр, эдийн засгийн орчин нь сайн биш засгийн газрын ажлын үр дүн муу байна хэмээн Хятадын зарим судлаачид үздэг. Монголын зарим засаг захиргааны байгууллагууд Хятадын талаас Монголын эдийн засаг, мөнгө санхүүгийн салбарт хөрөнгө оруулахыг дэмждэг хэдий ч бас Монголд бусад талаар ашиг тус авч ирэхийг хүсдэг. Жишээ нь их баялагийн нээлт хөгжлийн секторд оролцохын зэрэгцээ бас Монгол улсад усан цахилгаан станц байгуулах, орон сууц барих, засмал зам тавих гэх мэтийн асуудал давхар тавигддаг. Иймээс Хятадын тал Монгол руу хөрөнгө оруулахаас өмнөх хугацаанд Монголын талаас амлах амлалт нь сайн ажлын зөвшөөрөл гарах ахиц сайтай байдаг ба хөрөнгө мөнгөө оруулмагц тэдгээр удирдлагуудын ажил хийх нь залхуу хойрго болж төрийн бодлогын зохицуулалт нь шаардлага хангаж чаддаггүй юм. Засгийн газрын бодлого нь тогтвортой чанараар муу бөгөөд зарим нэгэн төрийн бодлого болон гэрээ хэлэлцээр нь маш хурдан хувирч өөрчлөгддөг. Энэ нь зохих хэмжээгээр хөрөнгө оруулагчдыг итгэл найдварыг мохоож байдаг ба Монгол руу худалдаа болон хөрөнгө оруулалтад сөргөөр нөлөөлдөг байна.

Дүгнэлт

1. Хилийн боомт дахь мөнгөн гүйлгээний үйлчилгээг сайжруулж хилийн худалдаанд дөхөм үзүүлэх хэрэгтэй. Хил орчмын бүсэд улирлын чанартай банкны салбар байгуулахад тухайн газрын засаг захиргаа ая таатай нөхцөл бүрдүүлж өгвөл зохистой.

Хилийн боомтоос ойрхон байгаа Хятадын хөдөө тосгоны итгэмжийн

7. Жан Чи Линг /姜其林/: “Банкны хооронд монгол төгрөг арилжаалах тухай анализ” (L), “Өвөр монголын мөнгөн гүйлгээ судлал” 2011 №8., 24-25-р тал: 蒙古图古里克实现银行间交易的现实性分析” (L), 《内蒙古金融研究》, 2011 (8) 24-25。

хоршоо (орон нутгийн чанартай банк) хилийн боомт дээрх үйлчилгээгээ сайжруулж боомт нээлтийн хугацаанд худалдаачдын мөнгө хадгалах болоод мөнгө солиход гаргах шаардлагыг хангавал зохино. Хятадын тал Монголын талын мөнгөн гүйлгээний харилцаа хийгээд ойлголтоо сайжруулж хилийн боомт дээр хоёр улсын хоорондох банкны дансны харилцааны ажлыг олшруулж хоёр улсын арилжаа худалдаачдын тооцоо хийх нөхцөлийг бүрэлдүүлж банкнаас гаднах бэлэн мөнгөний эргэлтийг багасгах хэрэгтэй. Хилийн боомтын гадаад худалдааны ажиллагааг сайтар дүрэмжүүлж олон улсын тооцооны дундах юаны үйлдлийг улам сайн хөгжүүлбэл зохино.

2. Хоёр улсын хоорондох валют солилцох ажлыг улам бүр ахиулж Монгол улс юаныг ашиглаж үндэсний валютаа тогтвортой байлгахыг дэмжвэл зохино. Одоогийн олон улсын мөнгөн гүйлгээний байдал тун тогтворгүй байгаа нөхцөлд юаны ханш харьцангуй тогтвортой байгаагаас Монголын төв банк нь юанаар гадаад валютын зах дээрх төгрөгийн ханшийг тогтворжуулж валют ханшны хэлбэлзэлтийг багасгавал зохистой.⁸

Хятад Монгол хоёр орны төв банкаас нэгэнтээ валют солилцох гэрээнд гарын үсэг зуржээ. Энэ нь хүрэлцээтэй мөнгөөр валют ханшны хэлбэлзэлтийг барихад ашигтай нөхцлийг бүрэлдүүлжээ. Хоёр орны засгийн газраас хөрөнгө мөнгө гаргаж, урьдаар зах дэлгүүрүүдийг тогтворжуулж дараа нь аажмаар хоёр орны арилжааны банкны ажиллагаа явуулахыг дэмжвэл зохино.

3. Хоёр орны хоорондох мөнгөн гүйлгээний сектор дахь хамтын ажиллагааг сайжруулж юань болон төгрөгийн хоорондох ханшыг шууд илэрхийлэх нь зүйтэй. Хоёр орны засгийн газар хийгээд төв банкнаас хил дамнасан юаны эргэлтэд хяналт тавьж хууль бусаар мөнгө арилжаалах ажиллагаанд анхаарлаа хандуулах хэрэгтэй. Монголын арилжааны банкны Хятадын хил орчмын бүсэд юаны тооцооны данс нээхийг дэмжиж Монголын хөрөнгө оруулагчид юанаар хилийн бүсэд шууд хөрөнгө оруулахыг урамшуулбал зохино. Хятадын төв банк, мөнгөн гүйлгээний байгууламж, гаалийн газар, татварын газар зэрэг салбарын харилцан хамаарлыг сайжруулж тогтмол хугацаатайгаар Монголын талтай харилцаж хилийн бүсэд бэлнээр эргэлдэж байгаа юаны байдал түүний тоо хэмжээ, жич Хятадын хөрөнгө оруулсан аж ахуйн компанийг Монголд хөрөнгө оруулсан байдлыг ойлгож хоёр орны холбогдох төрийн бодлогийг тогтоох болон түүнийг хэрэгжүүлэхэд үнэ цэнэ бүхий мэдээ мэдээлэлээр хангавал зохино.⁹

8. Жан Линг /张玲/: “Шинжааны хил дамнасан худалдааны тооцооны тухай санал зөвлөгөө”(L), “У Ханы арилжаа үйлчилгээний дээд сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл” 2011 он №12, 31-33-р тал: “推进新疆地区跨境贸易结算的对策”(L), 《武汉商业服务学院学报》, 2011 (12), 31-33。

9. Гуо Бин /郭斌/, Ван Ли Ли зэрэг /王丽丽 等/: “Юань болон хөрш орны үндэсний валютын хоорондох валют ханшны тухай”(L), “Баруун орны мөнгө санхүү” 2012, №3, 73-76-р тал: “加快人民币与周边小币种直接汇率挂牌探析”(L), 《西部金融》, 2012 (3), 73-76。

Ашигласан номзүй

- 1.3.5.9. Гуо Бин /郭斌/, Ван Ли Ли зэрэг /王丽丽 等/: “Юан болон хөрш орны үндэсний валютын хоорон дахь валют ханшны тухай”(L), “Баруун орны мөнгө санхүү” 2012, №3, 73-76-р тал : “加快人民币与周边小币种直接汇率挂牌探析”(L), 《西部金融》, 2012 (3) , 73-76
- 2.6. Жан И Жүн /张义军, Ген Фэн Жү /耿凤柱/: “Хятад Монголын хил залгасан оронд юаны эргэлдэж байгаа байдал” (L), “Өвөр монголын мөнгөн гүйлгээ судлал” 2012 №9., 48-49-р тал : “中蒙边境地区人民币区域化情况调查”(L), 《内蒙古金融研究》, 2012 (9) , 48-49
4. Дэн Жүн /邓忠/, Жао Мин /赵明/, Бао Жи Жүн /包志忠/: “Хилээр бэлнээр гарч байгаа юаныг хязгаарлах тогтоол Эрээний хилийн боомтын худалдаанд үзүүлсэн нөлөө” (L), “Өвөр монголын мөнгөн гүйлгээ судлал” 2012 №5., 36-37-р тал.: “携带人民币出入境限额规定对二连口岸贸易发展的影响”(L), 《内蒙古金融研究》, 2012 (5), 36-37
7. Жан Чи Линг /姜其林/: “Банкны хооронд монгол төгрөг арилжаалах тухай анализ” (L), “Өвөр монголын мөнгөн гүйлгээ судлал” 2011 №8., 24-25-р тал : “蒙古图古里克实现银行间交易的现实性分析”(L), 《内蒙古金融研究》, 2011 (8) 24-25
8. Жан Линг Линг /张玲玲/: “Шинжааны хил дамнасан худалдааны тооцооны тухай санал зөвлөгөө”(L), “У Ханы арилжаа үйлчилгээний дээд сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл” 2011 он №12., 31-33-р тал : “推进新疆地区跨境贸易结算的对策”(L), 《武汉商业服务学院学报》, 2011 (12) , 31-33